



ДУНДГОВЬ АЙМАГ  
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 08 өдөр

Дугаар А/127

Сангиндалай

Хорио цээрийн дэглэмийг цуцалж,  
хязгаарлалтын дэглэмд  
шилжүүлэх тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, 32 дугаар зүйлийн 32.1.8 дахь заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, 17.2.1 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.3 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 22-ний өдрийн 266 дугаар тогтоолоор батлагдсан хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Сангиндалай багийн нутаг дэвсгэр Гэр чулуун, Замын гашуун хэмээх газарт бог малын гоц халдварт мялзан өвчний голомт үүсээд 28 хоногийн дотор өвчний тохиолдол дахин илрээгүй тул 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдрөөс 06 дугаар сарын 19-ны өдрийн дуустал 14 хоногийн хугацаатайгаар 15 километр хорио цээрийн дэглэмийг цуцалж, хязгаарлалтын дэглэмд шилжүүлсүгэй.

2. Бог малын гоц халдварт мялзан өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд гамшгаас хамгаалах бие бүрэлдэхүүнийг үүрэгжүүлж ажиллахыг онцгой комиссын орлогч дарга (Г.Энхдэлгэр)-т даалгасугай.

3. Хязгаарлалтын бүсэд байгаа малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж, ариутгал, халдваргүйжүүлэлт хийж ажиллахыг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч О.Оюунчимэг), 6-р багийн Засаг дарга (Ж.Өлзийжаргал) нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ард иргэд, малчдыг мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх, мэдээ мэдээллээр хангаж ажиллахыг Тархвар зүйч (Т.Машбат) үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ  О.БАЗАРРАГЧАА



482302253